

БАТЛАВ.

ЗАХИРАЛ

Б.ШҮРЭНЧИМЭГ

**“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН IY АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН АНГИ  
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР**

2023-2024 оны хичээлийн жил

..... ангийн сурагч.....

Хугацаа 60 минут

**А хувилбар**

Нийт 24 оноо

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР:**

**САНАМЖ:** 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

**Нисдэг гутал**

Гутлын үйлдвэрийн хэсгийн ахлагч болсон нэгэн залуугийн цалин нэмэгдсэн тул гэрлэх бэлтгэл болгон шинэ байранд нүүн оржээ. Хоёр сар тэнд амьдарч, өдөрт хэд хэдэн удаа орж гардаг байсан ч хөршүүд нь түүнийг анзаарахгүй байв. Харин нэгдүгээр давхарт амьдардаг хүү огт өөр байлаа. Залуу гэрээсээ гарах бүрдээ цонхны цаанаас инээмсэглэн, гараараа даллах хүү рүү атга дүүрэн үнсэлт илгээдэг байв.

Хавар болоход залуу өнөөг хүртэл цонхны цаанаас хардаг байсан бяцхан найзтайгаа уулзах боломжтой болжээ. Гадаа дулаарсан учраас айлууд цонхоо онгойлгон, гэр дүүрэн цэцгийн үнэр тархан байлаа. Хүмүүсийн ярианаас тэр хүү ээжтэйгээ хоёулаа амьдардгийг мэдэж авчээ. Германд ажиллахаар явсан аав нь хэзээ нэгэн өдөр заавал ирэх гэнэ. Баяр ойртож байгаа тул хүүд бэлэг өгөхийг хүссэн залуу түүнээс ямар гуталд дуртай болохыг нь асуув. Хүү ийм бэлэг хүссэнгүй, харин алсыг ширтэн байж : “Би нисдэг гуталтай болмоор байна. Хүссэн газраа нисэн очихсон” гэжээ.

Залуу, хүүг мөрөөдлийнхөө ертөнцөд амьдардаг юм байна гэж бодов. Хүүхэд бүр ингэдэг шүү дээ. Тэгээд хүүд “Тийм гутал зөвхөн кинонд гардаг юм” гэж хэлэхэд хүү өөрийн хүслээсээ ухарсангүй. Баярын өдөр болоход залуу хэд хэдэн гутал аваад хүү дээр очив. Бяцхан хүүг бэлгээ авах гэж тогтож ядан байгаа байх гэж бодов. Хүү хаалгаа баяртайгаар нээгээд, дугуйтай сандал дээрээ тэгш суухыг оролдон байж : “Таниас нисдэг гутал хүсэж эвгүй байдалд оруулсандаа уучлал гуйж байна. Гэвч аавдаа өөр ямар нэг аргаар хүрч очиж чадахгүй шүү дээ” гэж инээмсэглэн хэлжээ.

**СОНГОХ ДААЛГАВАР:**

- 1.1 Гуталчин залуу яагаад шинэ байранд нүүж орох болсон бэ? /1 оноо/  
а. цалин нэмэгдсэн  
б. гэрлэхдээ бэлтгэж буй  
в. хэсгийн ахлагч  
г. орон байраа сайжруулах гэж
- 1.2 Яагаад залуу хүүгээс ямар гутал хэрэгтэй вэ гэж асуусан бэ? /1оноо/  
а. хүү гутал муутайг мэдээд  
б. хүү гоё гуталт дуртайг мэдээд

- c. өөрөө гутал хийдэг учраас
- d. хүүг гуталгүй гэж бодоод

1.3 “Бяцхан хүү бэлгээ авах гэж **тогтож ядан** байгаа байх гэж бодов” өгүүлбэрийн тодотгосон үгийг утга ойролцоо үгээр орлуулан өгүүлбэрийг бичээрэй. /1 оноо/

1.4 “**Инээмсэглэх**” гэдэгтэй ойролцоо утгатай үг бичээрэй. /1 оноо/

1.5 Зөөлрүүлэх үүргээр орсон “ь” –тэй үгийг олоорой. /1оноо/

- a. харья
- b. хэлье
- c. өгье
- d. бичье
- e. идье

1.6 Гуталчин залуугийн хийсэн үйлээс 2-ыг тоочин бичээрэй /1 оноо/

1.7 Эхэд утгад тохирох хэлцийг сонгоорой. /1оноо/

- a. гар цайлгах
- b. гар сунгах
- c. гар татах
- d. гар барих

1.8 “**Аргаар**” гэдэг үгийн балархай эгшигтэй ижил үүргээр бичигдсэн үг 1-ийг бичээрэй /1оноо/

1.9 “**Сайшаах**” үгийн эсрэг утгыг олоорой. /1оноо/

- A. буруутгах
- б. загнах
- в. магтах
- г. буруушаах

1.10 Балархай эгшиг нь гээгдсэн хэсгийг олоорой. /1оноо/

- a. гутлын, хэсгийн, болохоос, мөрөөдлийн
- b. хэсгийн, учраас, цэцгийн, мөрөөдлийн
- c. гутлын, үйлдвэрийн, цалингийн, мөрөөдлийн
- d. хэсгийн, бэлгээ, цэцгийн, гэрлэхээр

## ХОЁРДУГААР ХЭСЭГ:

2.1 Хүүгийн хийсэн үйл, хэлсэн үг тус бүрээс нэг нэгийг ялган бичээрэй. /2оноо/

2.2 Цэгийн оронд хаалтад байгаа үгсээс сонгон өгүүлбэрийг гүйцээж бичээрэй./3 оноо/  
**/сорьё, сорьё, урья, урья, харья, тарья, тарья, харья/**

Охиныг төрсөн өдөртөө .....	Хичээлээ тараад гэртээ .....
Тоо бодож оюунаа .....	Алсын уулыг .....
Ангараа мод .....	Ажлаа дуусгаад .....



БАТЛАВ.

ЗАХИРАЛ

Б.ШҮРЭНЧИМЭГ

**“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН IY АНГИЙН “МОНГОЛ ХЭЛ” ХИЧЭЭЛИЙН АНГИ  
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР**

2023-2024 оны хичээлийн жил

..... ангийн сурагч.....

Хугацаа 60 минут

**Б хувилбар**

Нийт 24 оноо

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР:**

**САНАМЖ:** 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

**Нисдэг гутал**

Гутлын үйлдвэрийн хэсгийн ахлагч болсон нэгэн залуугийн цалин нэмэгдсэн тул гэрлэх бэлтгэл болгон шинэ байранд нүүн оржээ. Хоёр сар тэнд амьдарч, өдөрт хэд хэдэн удаа орж гардаг байсан ч хөршүүд нь түүнийг анзаарахгүй байв. Харин нэгдүгээр давхарт амьдардаг хүү огт өөр байлаа. Залуу гэрээсээ гарах бүрдээ цонхны цаанаас инээмсэглэн гараараа даллах хүү рүү атга дүүрэн үнсэлт илгээдэг байв.

Хавар болоход залуу өнөөг хүртэл цонхны цаанаас хардаг байсан бяцхан найзтайгаа уулзах боломжтой болжээ. Гадаа дулаарсан учраас айлууд цонхоо онгойлгон, гэр дүүрэн цэцгийн үнэр тархан байлаа. Хүмүүсийн ярианаас тэр хүү ээжтэйгээ хоёулаа амьдардгийг мэдэж авчээ. Германд ажиллахаар явсан аав нь хэзээ нэгэн өдөр заавал ирэх гэнэ. Баяр ойртож байгаа тул хүүд бэлэг өгөхийг хүссэн залуу түүнээс ямар гуталд дуртай болохыг нь асуув. Хүү ийм бэлэг хүссэнгүй, харин алсыг ширтэн байж : “Би нисдэг гуталтай болмоор байна. Хүссэн газраа нисэн очихсон” гэжээ.

Залуу хүүг мөрөөдлийнхөө ертөнцөд амьдардаг юм байна гэж бодов. Хүүхэд бүр ингэдэг шүү дээ. Тэгээд хүүд “Тийм гутал зөвхөн кинонд гардаг юм” гэж хэлэхэд хүү өөрийн хүслээсээ ухарсангүй. Баярын өдөр болоход залуу хэд хэдэн гутал аваад хүү дээр очив. Бяцхан хүү бэлгээ авах гэж тогтож ядан байгаа байх гэж бодов. Хүү хаалгаа баяртайгаар нээгээд, дугуйтай сандал дээрээ тэгш суухыг оролдон байж : “Таниас нисдэг гутал хүсэж эвгүй байдалд оруулсандаа уучлал гуйж байна. Гэвч аавдаа өөр ямар нэг аргаар хүрч очиж чадахгүй шүү дээ” гэж инээмсэглэн хэлжээ.

**СОНГОХ ДААЛГАВАР:**

1.2 Гуталчин залуу гэрээсээ гарах бүрдээ ямар үйлдэл хийдэг байсан бэ? /1 оноо/

- a. Цонхны цаанаас инээмсэглэдэг.
- b. Гараараа далладаг.
- c. Цонхны цаанаас хардаг
- d. Атга дүүрэн үнсэлт илгээдэг

1.2 Хүү яагаад цонхны цаанаас хардаг байсан бэ? /1оноо/

- a. Ээжийгээ хүлээдэг байсан.
- b. Хүмүүсийг хардаг байсан.
- c. Аавыгаа ирнэ гэж хүлээдэг
- d. Гуталчин залуутай мэндлэх гээд

1.3 “Би нисдэг гуталтай болмоор байна. **Хүссэн газраа** нисэн очихсон гэлээ.”  
Өгүүлбэрийн тодотгосон үгийг утга ойролцоо үгээр орлуулан өгүүлбэрийг бичээрэй.  
/1 оноо/

.....

1.4 “**Зэмлэх**” гэдэгтэй ойролцоо утгатай үг бичээрэй. /1 оноо/

.....

1.5 Тусгаарлах үүргээр орсон “ь” –тэй үгийг олоорой. /1оноо/  
a. харья      b.хэлье      c. больё      d. тавья      e. урья

1.6 Хүүгийн хийсэн үйлээс 2-ыг тоочин бичээрэй /1 оноо/

.....

1.7 Эхийн утгад тохирох зүйр үгийг сонгоорой /1 оноо/

- a. Хүн хүндээ хүлэг эрчиндээ
- b. Ачийг ачаар, тусыг тусаар
- c. Ангир уургийг ээжээс, А үсгийг багшаас
- d. Хэлэхэд амар хийхэд хэцүү

1.8 “**Хаалгаа**” гэдэг үгийн балархай эгшигтэй ижил үүргээр бичигдсэн үг 1-ийг бичээрэй.  
/1оноо/

.....

1.9 “**Айх эмээх**” үгийн утгад тохирохгүй хэлц үгийг олоорой. /1оноо/

- a. Зүрх гаргах
- b. Зүрх үхэх
- c. Нүд нь орой дээрээ гарах
- d. Үнхэлцэг нь хагарах

1.10 Балархай эгшиг нь гээгдээгүй хэсгийг олоорой. /1оноо/

- a. гутлын, үйлдвэрийн , болохоос, мөрөөдлийн
- b . хэсгийн, учраас, цэцгийн, мөрөөдлийн
- c. болохоос, үйлдвэрийн , гэрлэхээр, үнэрийг
- d . хэсгийн, бэлгээ, мөрөөдлийн, гэрлэхээр

ХОЁРДУГААР ХЭСЭГ:



**IV анги” Монгол хэл” үнэлгээний даалгаврын хариу**

АТБХ	Сонгох даалгавар	Танин мэдэхүйн түвшин	Оноо	Хувилбар А	Хувилбар Б	Онооны тайлбар
Унших	1.1	Мэдлэг ойлголт	1оноо	b	d	Зөв сонгосон хариулт бүр 1 оноо
	1.2	Мэдлэг ойлголт	1оноо	c	c	
	1.3	чадвар	1оноо	байж ядан	Мөрөөдсөн газраа	
	1.4	чадвар	1оноо	мишээх. инээх	загнах, зандрах	
Бичих	1.5	Мэдлэг ойлголт	1 оноо	a	b	
	1.6	Мэдлэг ойлголт	1оноо	Асуултад оновчтой хариулсан бол	Асуултад оновчтой хариулсан бол	
	1.7	чадвар	1оноо	b	a	
Хэлзүй	1.8	Мэдлэг ойлголт	1оноо	Эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгасан.	Эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгасан.	
	1.9	чадвар	1оноо	d	a	
	1.10	чадвар	1 оноо	b	c	
<b>Задгай даалгавар</b>						
Унших	2.1	чадвар	2 оноо	Инээмсэглэн, гараараа далладаг. Би нисдэг гуталтай болмоор байна.	Үнсэлт илгээдэг. Тийм гутал зөвхөн кинонд гардаг юм.	Эхээс хийсэн үйл, хэлсэн үгийг оновчтой олж бүтэн өгүүлбэрээр бичсэн бол 2 оноо , дутуу бичсэн бол 1 оноо
бичих	2.2	чадвар	3 оноо	Урья, харья, сорьё, харъя, тарья, тарья	Урья, харья, сорьё, харъя, тарья, тарья	Зөв бичсэн хариулт бүр 0.5 оноо
хэлзүй	2.3	чадвар	2 оноо	<b>яагаад гэвэл</b> , ийм учраас	гэдгийг , учраас	Зөв бичсэн үг бүр 0.5 оноо
	2.4	чадвар	2 оноо	Ус туул, хойд өмнөд туйл, соронзны туйл	Хөлөг онгоц, шатрын хөлөг, хүлэг морь	Үгийн утгыг зөв тайлбарлан өгүүлбэрээ зохиосон бол 2 оноо , дутуу бол 1 оноо
бичих	2.5	хэрэглээ	5 оноо			Эхлэл, гол, төгсгөл хэсгийг бүтцийн дагуу зөв сайхан найруулан бичсэн бол 4 оноо, Зөв бичих: огт алдаагүй бол 1 оноо, 10- аас дээш алдвал 0 оноо \ алдаатай бичсэн үг бүр 0.1 оноо хасах\
НИЙТ	15 даалгавар			24 оноо		